БАТЛАВ
"ЭРДЭНЭТ ҮЙЛДВЭР" ТӨҮГ-ЫН
ЕРӨНХИЙ ИНЖЕНЕР
Т.БАТМӨНХ
2024 оны 12 сарын 11 өдөр

ЗЭСИЙН БАЯЖМАЛ ХАЙЛУУЛАХ, БОЛОВСРУУЛАХ ҮЙЛДВЭРЭЭС ГАРАХ ХАЯГДЛЫГ БОЛОВСРУУЛАХ ТЕХНОЛОГИЙН СУДАЛГАА, УРЬДЧИЛСАН ТЕХНИК ЭДИЙН ЗАСГИЙН ҮНДЭСЛЭЛ БОЛОВСРУУЛАХ ЗӨВЛӨХ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ АЖЛЫН ТЕХНИКИЙН ДААЛГАВАР

2024 оны ... сарын ... өдөр Дугаар Орхон аймаг

1. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ		
А	1	2
1.1	Захиалагч байгууллагын нэр, хаяг	"Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ, Монгол улс, Орхон аймаг, Баян-Өндөр сум, Найрамдал талбай, Захиргааны II-р байр.
1.2	Ажлын нэр	Зэсийн баяжмал хайлуулах, боловсруулах үйлдвэрээс гарах хаягдлыг боловсруулах технологийн судалгаа, урьдчилсан техник эдийн засгийн үндэслэл боловсруулах.
1.3	Шаардагдах хөрөнгийн хэмжээ, эх үүсвэр	"Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ-ын өөрийн хөрөнгөөр.
1.4	Төсөл хэрэгжих байршил, хамрах хүрээ	Орхон аймгийн "Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ-ыг түшиглэн байгуулах "Уул уурхай-металлурги-химийн үйлдвэрийн цогцолбор" Үйлдвэрлэл, технологийн паркийн талбай.
1.5	Ажил гүйцэтгэх үндэслэл	- Засгийн газрын 2019 оны 06 дугаар сарын 05-ны өдрийн 224 дүгээр тогтоол, "Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 06 дугаар сарын 18-ны өдрийн 262 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан "Эрдэнэт үйлдвэр төрийн өмчит үйлдвэрийн газрыг 2031 он хүртэл хөгжүүлэх үндсэн чиглэл", - Ерөнхий захирлын 2019 оны 08 дугаар сарын 06-ны өдрийн "Төсөл хэрэгжүүлэх тухай" А/701 дүгээр тушаал, - Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны Ашигт малтмал, газрын тосны газрын дэргэдэх Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөл (ЭБМЗ)-ийн 2022 оны 09 дүгээр сарын 05-ны СТР-2022-01 дугаартай "Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ-ыг түшиглэн байгуулах Үйлдвэрлэл, технологийн парк (ҮТП)-ийн зэсийн баяжмал хайлуулах, боловсруулах үйлдвэрийн техник эдийн засгийн үндэслэл (ТЭЗҮ)-ийг хэлэлцсэн дүгнэлтийн 20, 23 дахь заалтаар тусгагдсан даалгавар. Үүнд: • Байгаль орчны асуудлыг нарийвчлан судалж, аюултай хог хаягдал /хүнцэл агуулсан хатуу хаягдал г.м/ болон хог хаягдлыг шийдвэрлэх судалгаа, тооцоог нарийвчлан хийж, дайвар бүтээгдэхүүний борлуулалт, бусад холбогдох судалгааг хийж нарийвчилсан техник-эдийн засгийн үндэслэлд тусгах.

А	1	2
		• Аюултай хог хаягдлыг боловсруулах, аюулгүй болгох зориулалтын байгууламжийг барьж байгуулах ажлыг зохион байгуулж холбогдох судалгааг хийж нарийвчилсан техник-эдийн засгийн үндэслэлд тусгах.
1.6	Зорилго	ҮТП-ийн тогтвортой хөгжил, найдвартай үйл ажиллагааг хангахад Монгол улсын ногоон хөгжлийн бодлого, "Алсын хараа-2050" урт хугацааны бодлогын хүрээнд байгаль орчинд сөрөг нөлөө бага шинэ дэвшилтэт техник технологийг нэвтрүүлэхэд оршино. Зэсийн баяжмал хайлуулах, боловсруулах үйлдвэр (ЗБХБҮ)-ээс гарах аюултай хог хаягдал болох хүнцлийн сульфидыг боловсруулах, саармагжуулах, идэвхгүй тогтвортой төлөвт хувиргах, аюулгүй хадгалахтай холбоотой техник-технологийн судалгаа эдийн засгийн тооцоо зэрэгт үндэслэн оновчтой хувилбарыг тодорхойлох.
1.7	Зорилт	Үндсэн зорилгын хүрээнд дараах зорилтыг дэвшүүлэн ажиллана.Үүнд: 1. ЗБХБҮ-ээс гарах аюултай хог хаягдлын өнөөгийн нөхцөл байдлын шинжилгээг хийх, аюултай хог хаягдлыг ашиглах, боловсруулах, саармагжуулах технологийн суурь судалгааг хийх. 2. ЗБХБҮ-ээс гарах аюултай хог хаягдал болох хүнцлийн сульфидыг ижил төстэй үйлдвэрүүдэд тогтвортой төлөвт хувиргах байдлын техник, технологийн харьцуулалт, сонголт, шийдэлтэй холбоотой тооцоо, судалгааг хийх. 3. Хатуу хог хаягдлын талаар гаднын орнуудын туршлага болон олон улсын стандартуудыг судалж, манай орны нөхцөлд ашиглах боломжийг судлах, санал зөвлөмж боловсруулах. 4. Хүн амын суурьшлын болон үйлдвэрийн бүсүүдийн эрүүл ахуй, экологийн аюулгүй байдлын шаардлагыг хангах байдлыг тусгах. 5. Дээрх судалгаануудад үндэслэн хаягдал боловсруулах, байгаль орчинд үзүүлэх хор нөлөөг бууруулах, тогтвортой төлөвт хувиргах, хадгалах технологийн оновчтой сонголтыг хийх. 6. Технологийн процесс, хаягдал боловсруулах, хадгалах барилга байгууламж, ажлын талбайн зохион байгуулалт, хуваарилалтын уялдаа зэргийг тодорхойлох. 7. Хаягдал боловсруулах барилга байгууламжийн ерөнхий төлөвлөлт, гадна болон дотоод дэд бүтэц, бүрэлдэхүүн, бүтэц, хүчин чадал, хэмжээ, төсөв зэргийг боловсруулах. Монгол Улсын барилга, байгууламжид тавигдах үндсэн шаардлага, норм дүрэм, стандартад нийцүүлсэн байх. 8. Урьдчилсан ТЭЗҮ-д нийт хөрөнгө оруулалтын хэмжээ, үйл ажиллагаа хэвийн явагдах үеийн зардал, санхүүгийн тооцоог хийх.

A	1	2
		9. ЗБХБҮ-ээс гарах аюултай хог хаягдлыг боловсруулах, саармагжуулах, хадгалах, тээвэрлэх үйл ажиллагааны гарч болох эрсдэлүүдийг тодорхойлж, тэдгээрээс урьдчилан сэргийлэх арга хэмжээнүүдийг тодорхойлох, эрсдэлийн шинжилгээг хийх. 10. Шаардлагатай мэргэжилтэн ажилтнуудын хэрэгцээг тодорхойлж, тэдгээрийг бэлтгэх арга хэмжээг тооцож төлөвлөх.
2. ТАВИГДАХ ШААРДЛАГА		
2.1	Туршлага, ур чадвар	Зөвлөх үйлчилгээний ажлыг хуулийн этгээд гүйцэтгэх ба гүйцэтгэгч компани болон менежментийн баг нь дараах шаардлагыг хангасан байна. Үүнд: – Судалгаа, зөвлөх үйлчилгээний чиглэлээр 10-аас доошгүй жил үйл ажиллагаа явуулсан байх – Зөвлөх нь 5-аас доошгүй багийн гишүүдтэй байх ба химийн болон аюултай бодис, хог хаягдлыг чиглэлээр мэргэшсэн зөвлөхтэй байх – Зөвлөх багийн гишүүд англи хэлний ахисан түвшний мэдлэгтэй байх – ЗБХБҮ-ийн хаягдлыг боловсруулах технологийн судалгаа, ТЭЗҮ гүйцэтгэж байсан туршлагатай байх
2.2	Техникийн шаардлага	1. Зөвлөх хуулийн этгээд нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 14, 15, 16 дугаар зүйлийн шаардлагуудыг хангасан байна. 2. Гүйцэтгэгч (мэргэжилтэн эсвэл хуулийн этгээд) нь мэргэжлийн боловсон хүчинтэй байгууллага байна. 3. Зэсийн баяжмал хайлуулах, боловсруулах үйлдвэрээс гарах хаягдлыг боловсруулах технологийн судалгаа, урьдчилсан ТЭЗҮ боловсруулах ажил гүйцэтгэх явцад тус даалгаварт тусгагдаагүй асуудлыг харилцан тохиролцсоны үндсэнд техникийн даалгаварт нэмэлт өөрчлөлт оруулж болно.
2.3	Нөхцөл	– Ажлын даалгаварт тусгагдсан холбогдох судалгаа, шинжилгээг үндэслэн бодлогын судалгааны тайлан, Урьдчилсан ТЭЗҮ-ийг боловсруулж захиалагчид танилцуулах бөгөөд судалгааны ажлын эцсийн тайлан, Урьдчилсан ТЭЗҮ-ийн төслийг боловсруулна. – Боловсруулсан төсөл, судалгааны ажлын хүрээнд цуглуулсан мэдээлэл, судалгааны үр дүн, тайлан боловсруулагдсан программ хангамж нь “Зохиогчийн эрх болон түүнд хамаарах эрхийн тухай” хуулийн 17.2, 18 дугаар зүйлийн дагуу захиалагчийн өмч болно.

А	1	2
	3. ЗАХИАЛАГЧИЙН ХЯНАЛТ	
3.1	Ажлын хяналт, шалгалт	Гэрээт ажлын гүйцэтгэлд захиалагч талаас хүлээн зөвшөөрч баталсан гэрээ болон техникийн даалгаврын дагуу хяналтыг тавина. Захиалагч нь шаардлагатай үед хэдийд ч гүйцэтгэгчийн ажлын явцтай танилцах, ажлын гүйцэтгэлтэй холбоотойгоор нэмэлт мэдээ мэдээлэл гаргуулж авах эрхтэй.
3.2	Тайлан боловсруулалт, материал хүлээлгэн өгөх	Төслийн хүрээнд боловсруулсан, ашигласан бүх цахим болон хэвлэмэл материалуудыг эцсийн тайлангийн хамт захиалагчид хүлээлгэн өгнө. Тайланг хэвлэмэл байдлаар 3% болон CD хэлбэрээр хүлээлгэн өгнө.
	4. АЖИЛ ГҮЙЦЭТГЭХ ХУГАЦАА	
4.1	Ажил эхлэх	Ажил гүйцэтгэх гэрээнд заасан хугацаанд эхэлнэ.
4.2	Хугацаа	Захиалагч, гүйцэтгэгч талуудын хооронд гэрээ байгуулснаас хойш зөвлөх үйлчилгээний ажлыг гүйцэтгэх хугацаа 10 сар байна. Эхлэлийн тайлан: /90 хоногт гүйцэтгэнэ/ Дундын тайлан: /90 хоногт гүйцэтгэнэ/ Эцсийн тайлан: /90 хоногт гүйцэтгэнэ/

ТАНИЛЦСАН: